



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа  
сунгах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 28 дугаар зүйлийн 28.1.26, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Ерөнхий боловсролын Монгол сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс нэг жилийн хугацаагаар сунгасугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллахыг сургуулийн захирал /И Ган Э/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Б.Гантулга/, салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

